- "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" /Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол/
- "Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай" /Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол/
- ТБОНӨХБАҮХА ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ тогтоох тухай /Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол/

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль,

- Хөдөлмөрийн тухай хууль,
- Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэх батлах тухай /ЭМДҮЗ-ийн 2022 оны 1 дүгээр тогтоол/,
- Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай /ЭМДҮЗ-ийн 2022 оны 6 дугаар тогтоол/,
- Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай /ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол/,
- Журам шинэчлэн батлах тухай (Чанар, төлбөрийн хяналтын журам) /ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоол/,
- Эмнэлзүйн заавар батлах /ЭМС-ын 2022 оны А/77- А/82, А/147 дугаар тушаал/,
- Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар шинэчлэн батлах тухай /ЭМС-ын 2022 оны А/33 дугаар тушаал/,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай /ЭМС-ын 2022 оны А/136 дугаар тушаал/,
- Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам /ЭМС-ын 2022 оны А/346 дугаар тушаал/,
- Улсын хэмжээнд 2022-2025 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах тухай /ЭМС-ын 2022 оны А/475 дугаар тушаал/,
- Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай /ЭМС-ын 2022 оны А/407 дугаар тушаал/,
- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай /ЭМС-ын 2022 оны А/528 дугаар тушаал/,
- Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө /ЭМС-ын 2022 оны А/609 дугаар тушаал/,
- "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" /Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал/,
- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49/118 дугаар хамтарсан тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

УНТЭ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2018 оны А/26 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байгаа боловч шинэчлэгдсэн стандарт, хууль тогтоомж, гүйцэтгэлийн санхүүжилтийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтай холбоотой нэмэлт өөрчлөлтийг тусган шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,932,241.9 мянган төгрөгөөр буюу 14.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	52,005.7	5,092,874.2	5,040,868.5
Авлага	9,150,812.6	3,272,550.7	(5,878,261.9)
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	-	209,555.9	209,555.9
Бараа материал	6,841,813.1	10,881,245.7	4,039,432.6
Үндсэн хөрөнгө	50,831,617.8	57,352,491.1	6,520,646.9
Нийт хөрөнгө	66,876,249.2	76,808,483.3	9,932,241.9
Өр төлбөр	7,801,119.2	1,631,477.0	(6,159,642.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	59,075,130.0	75,117,014.2	16,101,884.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	66,876,249.2	76,788,483.3	9,932,241.9

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,092,874.2 мянган төгрөгт хүрч 5,040,868.5 мянган төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлийн санхүүжилт хэрэгжүүлсэн, цар тахлын нөлөө буурч эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн явуулах нөхцөл бүрдсэнтэй;
- Авлага дансны үлдэгдэл 3,272,550.7 мянган төгрөгт хүрч 5,878,261.9 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДЕГ-аас авах авлага буурсантай;
- Бараа материал дансны үлдэгдэл 10,881,245.7 мянган төгрөгт хүрч 4,039,432.6 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-аас 1,874,732.9 мянган төгрөгийн эм боох материал, хангамжийн материал үнэ төлбөргүй шилжиж ирсэнтэй,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50,831,617.8 мянган төгрөгт хүрч 6,520,646.9 мянган төгрөгөөр өссөн нь 1,409,077.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, үүнээс их засвар 872,303.1 мянган төгрөг, ЭМС-ын тушаалаар 9,104,465.7 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, 245,750.4 мянган төгрөгийн засвар, нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1,622,569.6 мянган төгрөгийн гадна зогсоолын тохижилтыг тоног төхөөрөмжийн хамт үнэ төлбөргүй хүлээн авсантай;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 78,367,500.6 мянган төгрөг болж 16,101,884.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,631,477.0 болж өмнөх оноос 6,159,642.3 мянган төгрөгөөр буурсан нь эм ханган нийлүүлэгч ААН байгууллагуудын өмнөх оны өрийг төлж барагдуулсантай тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМД-ын санхүүжилтээр 63,823,617.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 8,250,392.8 мянган төгрөг нийт зарлагыг 72,074,010.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж ТУЗ-ын 2022 оны 01 дүгээр тогтоолоор баталжээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл, цар тахлын үед эмнэлгийн бэлэн байдлыг хангах болон эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бэлдэх зэрэг асуудлуудтай холбогдуулан ТУЗ-ийн 2022 оны 06, 10, 13 дугаар тогтоолоор тус тус төсвийн тодотгол хийж, санхүүжилтийн эх үүсвэрийг 12,339,955.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 84,413,966.0 мянган төгрөгөөр баталсан. Үүний 72,297,346.8 мянган төгрөг нь ЭМДС-аас, 12,116,617.4 мянган төгрөг нь үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 90,409,726.4 мянган төгрөгийн мөнгөн орлого бүрдүүлсэн нь ТУЗ-өөр баталсан төлөвлөгөөт орлогоос 7.1 хувь буюу 5,996,855.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийт орлогын 80,288,450.0 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас, 10,121,276.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны зардалд нийт 85,369,957.0 мянган төгрөг зарцуулж төлөвлөсөн зардлаас 955,991.0 мянган төгрөг буюу 1.1 хувиар хэтэрсэн нь орлого 7.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Нийт зардлын гүйцэтгэлд нормативт зардал 1,666,916.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 779,198.5 мянган төгрөгөөр хэтэрсэн нь ЭМЯ-наас өгсөн албан даалгаврын дагуу цар тахлын үед эмнэлгийн нөөц бүрдүүлж, бэлэн байдлыг хангаж ажилласантай холбоотой байна.

Төсвийн төлөвлөгөөнөөс цалин хөлс 219,512.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 15,144.7 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 51,481.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 677,659.9 мянган төгрөг, томилолт зочны зардал 9,244.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 319,513.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	84,413,966.0	85,369,957.0	955,991.0	101.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	80,220,587.9	81,735,101.6	1,514,513.7	101.9
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,227,153.5	907,640.0	(319,513.5)	74.0
1.3	83601	Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	46,464.5	46,453.9	(10.6)	100.0
1.4	83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	2,919,760.1	2,680,761.5	(238,998.6)	91.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улсын нэгдсэн төв эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян суварга Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Юра, гэрээт аудитор О.Пүрэвдорж, аудиторын туслах Ч.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Мөнхзул, захирал С.Должинсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

УНТЭ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/219 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 64,684,991.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 646,849.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 80,530,106.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,845,115.1 мянган төгрөгөөр өссөн тул дахин тооцсон материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүнгээс 1 хувиар буюу 805,301.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон. Аудитын дахин тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75.0 хувиар тооцож 603,975.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

УНТЭ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөө баталж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан төсвийн байгууллагад хориглох 29 заалт тус бүрийг тусгасан хүснэгтээр биелэлтийг гаргуулан авч анхан шатны баримт болон журналуудтай тулган үзэхэд шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулаагүй, байгууллагын аваргад олгох мөнгөн шагнал болон бусад шагнал урамшууллын зардлыг гаргаагүйгээс 319,513.5 мянган, дотоод томилолт зочны зардлыг 7,260.4 мянган, албан хаагчид тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлаас 47,992.7 мянган төгрөгийг тус тус хэмнэж, нийт дүнгээр 374,766.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/134, А/414, А/519 дүгээр тушаалуудаар коронавируст халдварын хариу арга хэмжээнд шаардагдах 13,800 ширхэг 170,500.0 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл өрийн хэмнэлтийн/нэг удаагийн хэрэгсэл/-ийг үнэ төлбөргүй хүлээн

авч бүртгэсэн байна. Эдгээр хэрэгсэл нь оны эхэнд их хэмжээний үлдэгдэлтэй байсны зэрэгцээ ашиглагдаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх нөөцлөхийг хориглоно гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 3,512 мэдээллийг ил тод байршуулахаас 864,417.9 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст байршуулах мэдээ мэдээллийн асуудал хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмж өгөх.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын 818 байгууллагатай байгуулсан гэрээний биелэлт, хэрэгжилтийг түүвэрлэн шалгахад 35,889.8 мянган төгрөгийн 47 гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний биелэлтийг бүрэн биелсэн гэж дүгнэн акт үйлдсэн боловч 5,997.3 мянган төгрөгийн барааг дутуу нийлүүлсэн зэрэг нийт 41,887.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид заасны дагуу бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг үнэн зөв дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТХ тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 311,998.9 мянган төгрөгийн 9 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад биелэлт хангалтгүй 41,887.1 мянган төгрөгийн нийцлийн асуудлаарх зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 албан шаардлагыг биелүүлээгүй зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,404.6	1	1,404.6	100.0
Албан шаардлага	1	349,984.6			0
Зөвлөмж	4	9,346.2	4	9,346.2	100.0
Нийт дүн	6	360,735.4	5	10,750.8	83.3

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эмч, эмнэлгийн ажилтнуудыг гүйцэтгэлийн санхүүжилтээр цалин, урамшуулал олгохоор хэрэгжиж байгаа төслийн үйл ажиллагааны биелэлтэд горим сорил гүйцэтгэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 311,998.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 311,998.9 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Мөнгөн орлогын гүйлгээг бүртгэхдээ НБББББ-т тусгасан бичилтийг баримтлаагүйгээс 26,963.7 мянган төгрөгийг буруу бүртгэсэн; Мөнгөн орлогын 26,963.7 мянган төгрөгийн гүйлгээг данс буруу бүртгэсэн;
- Дабль аксиом консалтинг ХХК-тай байгуулсан НБББББ боловсруулах гэрээт ажил хийгдээгүй, гэрээний төлбөрийн 14,680.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэж тайлагнаагүй зөрчлийг арилгуулж, төлбөрийг буцаан төлүүлсэн;
- 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад мөнгөн хөрөнгө, өглөгийн дүн тус тус 1,099.1 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнагдсан; Санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн дансны эхний үлдэгдлийг 1,099.1 мянган төгрөгөөр өмнөх оны аудит хийсэн тайлангаас зөрүүтэй тайлагнасан;
- Жилийн эцсийн санхүүгийн тайланд тэтгэвэр тэтгэмжийн зардлын 452.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөгийн 68,718.2 мянган төгрөг, урьдчилгаа төлбөрийн 200,085.9 мянган төгрөгийн данс буруу ангилж бүртгэснийг;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 43,183.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 41,887.1 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,296.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Тайлант онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын 818 байгууллагатай байгуулсан гэрээний биелэлт, хэрэгжилтийг түүвэрлэн шалгахад 35,889.8 мянган төгрөгийн 47 гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээний биелэлтийг бүрэн биелсэн гэж дүгнэж акт үйлдсэн боловч 5,997.3 мянган төгрөгийн барааг дутуу нийлүүлсэн зэрэг нийт 41,887.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн, өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага өгөх

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч 3 байгууллагаас авах 1,296.0 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авлагын тайлан тооцоонд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай бүрэн тооцоо нийлж баталгаажуулах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 32 нэр төрлийн 1,269,206.1 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр

зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид ашиглагдах боломжгүй хөрөнгийн жагсаалтыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлгээ хийх арга хэмжээ авч ажиллах.

3. Санхүүжилтийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

ЭМДС-аас гүйцэтгэлээр нэхэмжилсэн орлогын дүн нь програмын хасалт, эмчийн хасалт гэсэн шалтгааны улмаас 3,018,736.0 мянган төгрөгөөр дутуу шилжиж орсон.

Энэ нь ЭМДҮЗ-ийн 2021 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам" шинэчлэн батлах тухай 03 дугаар тогтоолыг баримтлан ажиллаагүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж:

Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой батлагдсан эрхийн акт, заавар журмын мөрдөлтөд тавих дотоод хяналт, хэлтэс албад хоорондын харилцан хамаарал, ажлын уялдаа холбоог сайжруулж, ажил хариуцсан эмч, ажилтнуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлж ажиллах.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

УНТЭ-ийн ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар хуралдаанаар дархлаа дарангуйлах эмийн шууд гэрээ байгуулах худалдан авалтын тухай, 04 дүгээр хуралдаанаар байгууллагын төсвийн зарлагын хуваарьт өөрчлөлт оруулах тухай тус тус хэлэлцсэн боловч тэмдэглэл, шийдвэр байхгүй, 03 дугаар хуралдаанаар 4 асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн боловч 1 асуудлыг хэлэлцсэн боловч хурлын тэмдэглэл байхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг оновчтой тодорхойлж, хурлын тэмдэглэл, шийдвэр зэрэг баримт бичгийг цаг тухайд нь гаргаж албажуулан, үйл ажиллагааг жигдрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн орлогын гүйлгээг бүртгэхдээ НБББББ-т тусгасан бичилтийг баримтлаагүйгээс 26,963.7 мянган төгрөгийг буруу бүртгэсэн.	1	26,963.7						1	26,963.7			
Дабль аксиом консалтинг ХХК-тай байгуулсан НБББББ боловсруулах гэрээт ажил хийгдээгүй, гэрээний төлбөрийн 14,680.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэж тайлагнаагүй зөрчлийг арилгуулж, төлбөрийг буцаан төлүүлсэн.	1	14,680.0						1	14,680.0			
УНТЗ-ийн 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад мөнгөн хөрөнгө, өглөгийн дүн тус тус 1,099.1 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнагдсан.	1	1,099.1						1	1,099.1			
Жилийн эцсийн санхүүгийн тайланд тэтгэвэр тэтгэмжийн зардлын 452.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөгийн 68,718.2 мянган төгрөг, урьдчилгаа төлбөрийн 200,085.9 мянган төгрөг буюу нийт 269,256.1 мянган төгрөгийн бүртгэлийн алдааг тус тус залруулсан.	3	269,256.1						3	269,256.1			
Дүн	6	311,998.9						6	311,998.9			